



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Булган аймгийн Хангал сумын нутаг дахь “Спорт бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нэгтгэн өөрчлөн зохион байгуулж, “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар байгуулсантай холбогдуулан нэгдэж буй төрийн өмчит үйлдвэрийн газруудын хаалтын балансыг гаргаж, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэхтэй холбогдон үүсэх бусад асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга

Гишүүд:

Д.Тунгалагтуул

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

С.Мөнх-Эрдэнэ

Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого,
төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

А.Өнөрцэцэг

Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү,
хөрөнгө оруулалтын хэлтсийн Төсвийн
төвлөрүүлэн захирагчийн төсвийн ерөнхий
нягтлан бодогч

Б.Наран-Идэр

“Техник спортын төв” аж ахуйн тооцоотой төрийн
өмчит үйлдвэрийн газрын захирал

132005078

ТӨБЗГ тушаал-/2022

О.Баярбат “Спортын бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал


Э.Мөнхболд “Техник спортын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч


О.Батдэлгэр “Спортын бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч

Нарийн бичиг:
Г.Нямдаваа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын
хэлтсийн мэргэжилтэн

Д.Сонинбилэг “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн
газрын бичиг хэргийн ажилтан

- 2.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
- 3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус ажлын хэсэгт орсон албан хаагчдын томилолтын зардлын төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.
4. Албан хаагчийн унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд)-т зөвшөөрсүгэй.
- 5.Ажлын хэсгийн нэгдсэн санал, дүгнэлтийг 2022 оны 4 дүгээр сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэг /В.Дарханбаатар/-д даалгасугай.





Төрийн өмчийн бодолго, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 03 дугаар сарын
24 өдрийн **4/24** дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Нэг: Зорилго

Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спорт бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэхтэй холбогдон үүсэх бусад асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсэг энэхүү удирдамжийг баримтална.

Хоёр: Хийгдэх ажлын чиглэл

1. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн ба эргэлтийн хөрөнгөд тооллого хийж, акт үйлдэн бүртгэх;
2. Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн ба эргэлтийн хөрөнгөд тооллого хийж, акт үйлдэн бүртгэх;
3. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын нийгмийн даатгал, татвар болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог нэгтгэн гаргах, тооцоо нийлсэн акт үйлдэх, санхүүгийн хаалтын балансыг гаргах;
4. Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын нийгмийн даатгал, татвар болон бусад өр төлбөр, ажиллагсадтай хийх өр, авлагын тооцоог нэгтгэн гаргах, тооцоо нийлсэн акт үйлдэх, санхүүгийн хаалтын балансыг гаргах;
5. “Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын бичиг баримтыг архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
6. Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын бичиг баримтыг архивт шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
7. Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх арга хэмжээ авах;

8. Булган аймгийн Хангал сумын нутаг дахь "Спортын бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийг зохих журмын дагуу "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх арга хэмжээ авах;

9. "Техник спортын төв" төрийн өмчит үйлдвэрийн газар болон Булган аймгийн Хангал сумын нутаг дахь "Спортын бэлтгэл, сургалтын төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгийг зохих журмын дагуу "Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв" аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэхтэй холбогдон үүсэх бусад асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх.

Гурав: Үр дүн, хугацаа

Ажлын хэсгийн тайлан, цаашид авах арга хэмжээний талаарх санал дүгнэлтээ 2022 оны 4 дүгээр сард багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаан танилцуулах.

.....000.....

Төрийн өмчийн бодолго, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 03 дугаар сарын
24. өдрийн *24* дугаар тушаалын 2 дугаар хавсралт
24

Орон нутагт томилолтоор ажиллах удирдамж, зардлын төсөв

Нэг. Ерөнхий мэдээлэл

Албан томилолтын ажлын зорилго, чиглэл:

Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Техник спортын төв” ТӨҮГ, Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” ТӨҮГ-ын эд хөрөнгийг зохих журмын дагуу “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх ажлаар.

Албан томилолтоор ажиллах хугацаа:

2022 оны 4 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд хуанлийн 2 хоногийн хугацаанд гүйцэтгэнэ.

Албан томилолтоор ажиллах нэгж:

Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газар

Хоёр. Албан томилолтоор хийж гүйцэтгэх ажил үүрэг

Булган аймгийн Хангаль сумын нутаг дахь “Спортын бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгөд тооллого хийх, зохих журмын дагуу акт, баримт бүрдүүлэн “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлаар.

| № | Чиглэл | Тоо | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ /төг/ | Хянасан |
|--|---|-------|-------------|----------------|----------------|------------|
| Тээврийн зардал / 100 км-т 20 л тулш, 1л тулш 2590 төг/ Томилолт 3 албан хаагч 2 хоног 1 машин | | | | | | |
| 1 | Улаанбаатараас Булган аймгийн Хангаль сум, Булган аймгийн Хангаль сумсаас Улаанбаатар хот | 550x2 | км | 2590 | 220x2590 | 569,800.00 |
| 2 | Томилолтын зардал | 3 | хоног | 36000x2 | 72000x3 | 216,000000 |
| Нийт зардал | | | | | 785,800.00 | |

Тоогоор /785,800.00./ төгрөг, үсгээр / долоон зуун наян таван мянга найман зуун/ төгрөг.

Тайлбар: Сангийн сайдын 2018 оны 301 тоот тушаалаар батлагдсан томилолтын зардлын нормативыг үндэслэн тооцов.

.....000.....